

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2025/039/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Баянхонгор хот 2025.02.24	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: М.Алтантуяа Утас: 99061829 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn Аудитор: Г.Энхзул Утас: 99333147 Цахим хаяг: enkhzulg@audit.gov.mn Цахим хуудас: www.audit.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	13
4. АУДИТЫН ТАЙЛАН	16
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement_bayankhongor@audit.gov.mn

2025.02.24 № 2/25
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

5020204

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 хөтөлбөр, 12 зорилт, 56 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 97.6 хувиар үнэлсэн байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	94,795,812.96	288,371,801.86
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,291,999.00	9,291,999.00
312	Банканд байгаа бэлэн мөнгө	1,291,999.00	9,291,999.00
3121	Төгрөг	1,291,999.00	9,291,999.00
31211	Төрийн сангийн харилцах	1,291,999.00	9,291,999.00
33	АВЛАГА	00.00	145,319,719.78
33300	Татаас, санхүүжилтийн авлага	00.00	139,921,016.03
335	Бусад авлага	00.00	5,398,703.75
3351	Байгууллагаас авах авлага	00.00	5,398,703.75
35	БАРАА МАТЕРИАЛ	93,503,813.96	133,760,083.08
351	Түүхий эд материал	68,291,197.06	61,567,019.19
35110	Тусгай зориулалттай материал	23,289,189.39	17,968,790.46
35130	Эм боох материал	45,002,007.67	43,598,228.73
35300	Бэлэн бүтээгдэхүүн	1,032,235.00	1,024,685.00
354	Хангамжийн материал	24,180,381.90	71,168,378.89
35410	Бичиг хэргийн материал	4,006,950.00	22,385,350.00
35420	Аж ахуйн материал	17,688,131.00	31,593,640.00
35430	Сэлбэг хэрэгсэл	00.00	1,480,000.00
35440	Түлш, шатах тослох материал	00.90	1,010,088.89
35450	Барилгын засварын материал	370,000.00	12,874,000.00
35470	Бусад хангамжийн материал	2,115,300.00	1,825,300.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	405,605,579.17	1,630,291,763.36
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	405,605,579.17	1,630,291,763.36
392	Биет хөрөнгө	370,055,579.17	1,520,116,763.36
39201	Барилга, байгууламж, орон сууц	154,246,171.96	1,318,956,740.76
39202	Хуримтлагдсан элэгдэл	(18,027,791.88)	(49,172,806.17)
39203	Авто-гээврийн хэрэгсэл	47,600,000.00	47,600,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(8,330,000.07)	(13,090,000.11)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	391,353,059.00	428,662,069.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(214,590,874.53)	(230,894,886.45)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	46,733,633.30	48,933,633.30
39208	Хуримтлагдсан элэгдэл	(31,642,132.39)	(33,269,653.89)
39209	Зам, гүүрний байгууламж	3,500,000.00	3,500,000.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(874,999.80)	(1,108,333.08)
39214	Бусад үндсэн хөрөнгө	2,000,000.00	2,000,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,911,486.42)	(2,000,000.00)
393	Биет бус хөрөнгө	35,550,000.00	110,175,000.00
39301	Программ хангамж	1,061,000.00	1,061,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,061,000.00)	(1,061,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	35,550,000.00	110,175,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	500,401,392.13	1,918,663,565.22
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	40,127,763.81	2,112,926.89
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	40,127,763.81	2,112,926.89
413	Өглөг	40,127,763.81	2,112,926.89
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	40,127,763.81	2,112,926.89
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	460,273,628.32	1,916,550,638.33
51	Засгийн газрын хувь оролцоо	460,273,628.32	1,916,550,638.33
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	96,568,996.01	96,568,996.01
51101	Өмч: - төрийн	96,568,996.01	96,568,996.01

Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

512	Хуримтлагдсан үр дүн	318,265,933.22	1,774,542,943.23
51210	Өмнөх үеийн үр дүн	318,265,933.22	318,265,933.22
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	1,456,277,010.01
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	45,438,699.09	45,438,699.09
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	500,401,392.13	1,918,663,565.22

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	175,975,428.39	2,595,599,515.30
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	117,997,028.39	2,053,001,604.80
120	Нийтлэг татварын бус орлого	117,997,028.39	2,053,001,604.80
120002	Хүүгийн орлого	00.00	1,239,335,568.80
120003	Торгуулийн орлого	48,152,778.39	1,023,100.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	69,844,250.00	812,642,936.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	69,844,250.00	348,268,136.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	464,374,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	57,978,400.00	542,597,910.50
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	57,423,400.00	488,509,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	57,423,400.00	488,509,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	555,000.00	54,088,310.50
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	9,600,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	26,432,310.50
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	555,000.00	18,056,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	114,869,913.66	1,139,322,505.29
21	УРСГАЛ ЗАРДАЛ	114,869,913.66	1,139,322,505.29
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	114,144,913.66	924,852,988.29
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	58,943,382.91	499,116,904.00
210101	Үндсэн цалин	47,935,278.91	304,578,020.00
210102	Нэмэгдэл	9,253,104.00	136,957,984.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,755,000.00	15,536,500.00
210104	Урамшуулал	00.00	42,044,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,367,925.81	60,716,413.72
210201	Тэтгэврийн даатгал	5,778,005.13	39,340,834.05
210202	Тэтгэмжийн даатгал	397,479.46	5,005,649.19
210203	ҮОМШӨ-ний даатгал	317,983.60	4,652,560.24
210204	Ажилгүйдлийн даатгал	79,495.86	2,343,471.45
210205	Эрүүл мэндийн даатгал	794,961.76	9,373,898.79
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,143,826.85	109,709,163.08
210301	Гэрэл, цахилгаан	2,110,985.85	10,861,065.08
210302	Түлш, халаалт	26,900,331.00	85,898,320.00
210303	Цэвэр, бохир ус	1,132,510.00	5,801,378.00
210304	Байрны түрээс	00.00	7,148,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,555,879.33	24,564,410.94
210401	Бичиг хэрэг	209,950.00	6,549,940.00
210402	Тээвэр, шатахуун	00.00	3,143,862.01
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	845,800.00	3,044,940.00

Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210404	Ном, хэвлэл	00.00	128,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	100,000.00	1,200,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	400,129.33	4,664,570.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	5,833,098.93
2105	Нормативт зардал	7,058,487.36	39,299,308.94
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	7,058,487.36	35,948,818.94
210502	Хоол, хүнс	00.00	3,350,490.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	36,253,400.00
210604	Урсгал засвар	00.00	36,253,400.00
2107	Томилолт, зочны зардал	273,200.00	46,278,623.00
210702	Дотоод албан томилолт	273,200.00	46,278,623.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	90,000.00	40,317,420.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	32,100,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	619,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	55,960.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	6,238,000.00
210807	Газрын төлбөр	00.00	255,960.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	90,000.00	1,057,650.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,712,211.40	68,597,344.61
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	115,000.00	900,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	85,000.00	66,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	8,512,211.40	67,631,344.61
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	725,000.00	214,459,867.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	725,000.00	116,155,116.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	34,471,600.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	20,283,516.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	725,000.00	61,400,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	98,304,751.00
213302	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө	00.00	98,304,751.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	61,105,514.73	1,456,277,010.01
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	61,105,514.73	1,456,277,010.01

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /төгрөгөөр/
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	643,135,177.10	1,355,240,846.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	370,503,011.10	812,642,936.00
120	Нийтлэг татварын бус орлого	370,503,011.10	812,642,936.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	370,503,011.10	812,642,936.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	368,319,042.00	348,268,136.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	464,374,800.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	2,183,969.10	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	272,632,166.00	858,251,694.47
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	233,400,899.00	488,509,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	232,108,900.00	488,509,600.00

Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

131003	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,291,999.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	39,231,267.00	369,742,094.47
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	9,600,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	26,432,310.50
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	41,415,236.10	333,709,783.97
131106	Төсвийн урамшуулал	28,075,767.00	00.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	621,602,948.10	1,294,258,886.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	621,602,948.10	1,294,258,886.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	522,400,212.16	940,478,003.47
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	325,300,399.45	503,962,271.47
210101	Үндсэн цалин	212,206,933.09	284,585,837.00
210102	Нэмэгдэл	85,853,561.76	156,639,814.50
210103	Унаа хоолны хөнгөлөлт	16,902,826.58	19,401,815.00
210104	Урамшуулал	10,337,078.02	43,334,804.97
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	40,662,499.71	61,869,750.00
210201	Тэтгэврийн даатгал	27,804,381.54	43,486,550.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,214,526.39	4,595,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,571,624.05	2,297,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	642,905.21	2,297,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,429,062.52	9,191,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,025,600.00	147,724,000.00
210301	Гэрэл, цахилгаан	9,339,057.89	10,861,065.08
210302	Түлш, халаалт	23,369,256.11	123,839,156.92
210303	Цэвэр, бохир ус	4,317,286.00	5,801,378.00
210304	Байрны түрээс	00.00	7,222,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	7,082,992.00	32,539,300.00
210401	Бичиг хэрэг	1,599,832.00	4,640,690.00
210402	Тээвэр, шатахуун	1,000,000.00	2,480,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,383,160.00	3,086,740.00
210404	Ном, хэвлэл	00.00	19,628,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	600,000.00	1,200,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,500,000.00	1,503,070.00
2105	Нормативт зардал	21,999,999.90	42,091,940.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	19,999,999.90	34,816,340.00
210502	Хоол, хүнс	00.00	2,951,290.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,000,000.00	4,324,310.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,719,534.00	62,701,299.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,720,570.00	6,856,600.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,999,664.00	00.00
210604	Урсгал засвар	4,999,300.00	55,844,699.00
2107	Томилолт, зочны зардал	9,999,891.00	47,351,773.00
210702	Дотоод албан томилолт	9,999,891.00	47,351,773.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,744,060.00	39,256,670.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,050,000.00	31,734,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	60,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	697,500.00	619,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	61,360.00	55,960.00

Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	33,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	500,000.00	6,290,500.00
210807	Газрын төлбөр	136,000.00	255,960.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	6,200.00	00.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,200,000.00	299,850.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	44,865,236.10	2,981,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	43,865,236.10	2,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,000,000.00	981,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	99,202,735.94	353,780,883.03
2132	Бусад урсгал шилжүүлэг	35,836,700.00	115,555,116.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	32,797,500.00	33,490,600.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	20,283,516.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,039,200.00	61,781,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	8,000,000.00	238,225,767.03
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	139,921,016.03
213304	Хөрөнгийн	8,000,000.00	98,304,751.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	55,366,035.94	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	55,366,035.94	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	21,532,229.00	60,981,960.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	22,279,430.00	52,981,960.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	22,279,430.00	52,981,960.00
2200	Дотоод эх үүсвэрээр	22,279,430.00	52,981,960.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	22,279,430.00	52,981,960.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(22,279,430.000)	(52,981,960.000)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(747,201.00)	8,000,000.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,039,200.00	1,291,999.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,291,999.00	9,291,999.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Төгрөгөөр/
						Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	96,568,996.01	54,112,803.69	52,859,073.74	00.00	203,540,873.44
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	96,568,996.01	54,112,803.69	52,859,073.74	00.00	203,540,873.44
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	78,084,708.64	00.00	78,084,708.64

C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	96,568,996.01	45,438,699.09	318,265,933.22	00.00	460,273,628.32
D01	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	96,568,996.01	45,438,699.09	318,265,933.22	00.00	460,273,628.32
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	96,568,996.01	45,438,699.09	318,265,933.22	00.00	460,273,628.32
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	1,456,277,010.01	00.00	1,456,277,010.01
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	96,568,996.01	45,438,699.09	1,774,542,943.23	00.00	1,916,550,638.33

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН				100.
		738,509,900.00	738,472,985.00	36,915.00	00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	738,509,900.00	738,472,985.00	36,915.00	100.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	683,754,300.00	683,717,869.00	36,431.00	99.99
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	459,578,400.00	459,578,400.00	0.00	100.00
210101	Үндсэн цалин	282,311,000.00	284,585,837.00	(2,274,837.00)	100.81
210102	Нэмэгдэл	135,365,600.00	134,776,002.00	589,598.00	99.56
210103	Унаа хоолны хөнгөлөлт	21,945,000.00	19,401,815.00	2,543,185.00	88.41
210104	Урамшуулал	19,956,800.00	20,814,746.00	(857,946.00)	104.30
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	57,447,300.00	57,447,400.00	-100.00	100.00
210201	Тэтгэврийн даатгал	39,064,200.00	39,064,200.00	0.00	100.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,595,800.00	4,595,800.00	0.00	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,479,900.00	2,297,900.00	182,000.00	92.66
210204	Ажилгүйдлийн даатгал	2,115,800.00	2,297,900.00	(182,100.00)	108.61
210205	Эрүүл мэндийн даатгал	9,191,600.00	9,191,600.00	0.00	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	71,274,400.00	71,274,400.00	0.00	100.00
210301	Гэрэл, цахилгаан	12,705,200.00	10,861,065.08	1,844,134.92	85.49
210302	Түлш, халаалт	53,000,000.00	54,611,956.92	(1,611,956.92)	103.04
210303	Цэвэр, бохир ус	5,569,200.00	5,801,378.00	(232,178.00)	104.17
2104	Хангамж, бараа материалын зардал	7,825,600.00	7,825,600.00	0.00	100.00
210401	Бичиг хэрэг	1,569,600.00	1,585,890.00	(16,290.00)	101.04

Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210402	Тээвэр, шатахуун	981,000.00	980,800.00	200.00	99.98
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,603,500.00	2,555,840.00	47,660.00	98.17
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,200,000.00	1,200,000.00	0.00	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,471,500.00	1,503,070.00	(31,570.00)	102.15
2105	Нормативт зардал	27,275,600.00	27,275,600.00	0.00	100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	20,000,000.00	20,000,000.00	0.00	100.00
210502	Хоол, хүнс	2,887,000.00	2,951,290.00	(64,290.00)	102.23
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,388,600.00	4,324,310.00	64,290.00	98.54
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,993,000.00	11,992,559.00	441.00	100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,993,000.00	11,009,560.00	(16,560.00)	100.15
210604	Урсгал засвар	1,000,000.00	982,999.00	17,001.00	98.30
2107	Томилолт, зочны зардал	12,000,000.00	12,000,000.00	0.00	100.00
210702	Дотоод албан томилолт	12,000,000.00	12,000,000.00	0.00	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	33,378,600.00	33,342,910.00	35,690.00	99.89
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	31,735,700.00	31,734,900.00	800.00	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	619,500.00	619,500.00	0.00	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	56,000.00	55,960.00	40.00	99.93
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	34,300.00	00.00	34,300.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	490,500.00	490,500.00	0.00	100.00
210807	Газрын төлбөр	142,200.00	142,200.00	0.00	100.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	400.00	00.00	400.00	0.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	300,000.00	299,850.00	150.00	99.95
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2981400.00	2981000.00	400.00	99.99
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,000,400.00	2,000,000.00	400.00	99.98
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	981,000.00	981,000.00	0.00	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	54755600.00	54755116.00	484.00	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	54,755,600.00	54,755,116.00	484.00	100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	33,490,600.00	33,490,600.00	0.00	100.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	20,284,000.00	20,283,516.00	484.00	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	981,000.00	981,000.00	0.00	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	738,509,600.00	738,472,985.00	36,615.00	100.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	488,509,600.00	488,472,985.00	36,615.00	99.99

Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

131001	Улсын төсвөөс санхүүжих	488,509,600.00	488,472,985.00	36,615.00	99.99
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	250,000,000.00	250,000,000.00	0.00	100.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	250,000,000.00	250,000,000.00	0.00	100.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	13.00	13.00	0.00	100.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	09.00	09.00	0.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	01.00	01.00	0.00	100.00
620004	Гэрээт ажилтан	02.00	02.00	0.00	100.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	13.00	13.00	0.00	100.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	04.00	04.00	0.00	100.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	08.00	08.00	0.00	100.00
650010	Гэрээт ажилтан	01.00	01.00	0.00	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
1	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	41,415,236.10	369,742,094.47
21	УРСГАЛ ЗАРДАЛ	41,415,236.10	369,742,094.47
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	41,415,236.10	309,742,094.47
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		44,383,871.47
210102	Нэмэгдэл		21,863,812.50
210104	Урамшуулал		22,520,058.97
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		4,422,350.00
210201	Тэтгэврийн даатгал		4,422,350.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		76,449,600.00
210302	Тулш, халаалт		69,227,200.00
210304	Байрны түрээс		7,222,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал		24,713,700.00
210401	Бичиг хэрэг		3,054,800.00
210402	Тээвэр, шатахуун		1,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		530,900.00
210404	Ном, хэвлэл		19,628,000.00
2105	Нормативт зардал		14,816,340.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		14,816,340.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		103,690,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		46,129,000.00
210602	Тавилга		2,500,000.00
210604	Урсгал засвар		55,061,700.00
2107	Томилолт, зочны зардал		35,351,773.00
210702	Дотоод албан томилолт		35,351,773.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,550,000.00	5,913,760.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,550,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		5,800,000.00

210807	Газрын төлбөр		113,760.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	38,865,236.10	0.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	38,865,236.10	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		60,000,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	41,415,236.10	369,742,094.47
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	41,415,236.10	369,742,094.47
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		26,432,310.50
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	41,415,236.10	333,709,783.97
131106	Төсвийн урамшуулал		9,600,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	00.00	00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтэс эрхэм зорилгоо “Монгол улсын хөгжлийн стратеги, чиг хандлагад нийцүүлэн улс орон, нийгэм, эдийн засгийн аюулгүй байдлыг хангаж, экспортыг нэмэгдүүлж, үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд стандартчилал, хэмжил зүй, тохирлын үнэлгээ, сорьцын хяналтын бодлогоор дэмжлэг үзүүлэхэд оршино.” гэж тодорхойлжээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудит/аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Баянхонгор Стандарт, хэмжил зүйн хэлтэс 2020 оны " Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг үйл ажиллагаандаа ашиглаж, санхүүгийн тайлан бэлтгэхдээ мөрдөж ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2024 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1. Аж ахуйн нэгж, байгууллага дараах бүртгэлийн стандартыг дагаж мөрдөнө: 4.1.3-д "Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,418,262.2 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	94,795.80	288,371.80	193,576.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,292.00	9,292.00	8,000.00
33	АВЛАГА	0	145,319.70	145,319.70
35	БАРАА МАТЕРИАЛ	93,503.80	133,760.10	40,256.30
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	405,605.60	1,630,291.80	1,224,686.20
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	405,605.60	1,630,291.80	1,224,686.20
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	500,401.40	1,918,663.60	1,418,262.20
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	40,127.80	2,112.90	(38,014.90)
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	40,127.80	2,112.90	(38,014.90)
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	460,273.60	1,916,550.60	1,456,277.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	500,401.40	1,918,663.60	1,418,262.20

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 9,292.0 мянган төгрөг нь Ахмадын сан 100030009501 дансны үлдэгдэл байна.

Авлагын дансны үлдэгдэл нь Үндсэн үйл ажиллагааны давсан орлогоос зарцуулах эрхийг Сангийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 224 дугаар тушаалаар сорьцын лабораторид тоног төхөөрөмж авахаар 94,556.0 мянган төгрөгийн тендер зарласан үнэ, Говь хангай мебельтэй ерөнхий гэрээний үндсэн дээр байгуулсан тавилга, эд хогшил авах үлдэгдэл нийт 139,921.0 мянган төгрөгийг

буцаан төвлөрүүлсэн байна. Мөн ажиллагсадтай холбогдсон авлага, Бусад зардлын тооцооны авлага 5,398.7 мянган төгрөг байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,630,291.8 мянган төгрөг болж өмнөх оноос 1,224,686.2 мянган төгрөгөөр өссөн байна. Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 01 сарын 25-ны өдрийн 33 дугаар тогтоолоор 1,239,335.6 мянган төгрөгийн барилга, байгууламж, биет бус хөрөнгө Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанаас шилжүүлэн авсан. Аймгийн Засаг даргын 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн А/572 тоот захирамж, Монгол Улсын Сангийн Сайдын 2024 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн 224 тоот "Улсын төсвийн байгууллагын үйл ажиллагааны давсан орлогоос зарцуулах эрх олгох" тухай тушаалыг үндэслэн давсан орлогын эх үүсвэрээс 52,981.9 мянган төгрөгөөр тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдаж авсан байна.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 697 дугаар тогтоол Үндсэн хөрөнгө акталж данснаас хасах зөвшөөрөл олгох тухай шийдвэрийг үндэслэн 13,472.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө данснаас хассан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 133,760.1 мянган төгрөг болж өмнөх оноос 40,256.3 мянган төгрөгөөр өссөн байна. Тайлант онд бусад байгууллагаас 2,655.2 мянган төгрөгийн бараа материал үнэгүй авсан ба бичиг хэрэг, шуудан холбоо, интернэтийн төлбөр өмнөх оноос ихэссэн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 664,404.8 мянган төгрөгөөр тооцон зардлыг санхүүжүүлэхээр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Тайлант онд цалингийн сан нэмэгдсэнтэй холбоотой төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 74,104.8 мянган төгрөгөөр илүү, 738,509.9 мянган төгрөг болгож баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд улсын төсвийн санхүүжилтээр 738,509.6 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлснээс урсгал үйл ажиллагаанд 738,472.9 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдлийг төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	652,018.30	651,982.90	(35.40)	99.99
2	80219 Харуул, хамгаалалтын зардал	30,600.00	30,600.00	-	100.00
3	80224 Зөвлөл, хороо, комиссын гишүүд	400.00	399.20	(0.80)	99.80
4	80227 Лабораторийн итгэмжлэл	735.70	735.70	-	100.00
5	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж	54,755.60	54,755.10	(0.50)	100.00
Нийт дүн		738,509.60	738,472.90	(36.70)	99.96

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 54,088.3 мянган төгрөг орсныг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Хүснэгт 2. Нэмэлт санхүүжилтийн орлого

Байгууллагын нэр	Орлого
Баянхонгор аймгийн Засаг дарга	36,032.30
Голомт банк	17,871.00
Хаан банк	185.00
Нийт дүн	54,088.30

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд Грийн химисрти ХХК-аас 8,459.1 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, Ээл гранд ХХК-аас 14,100.0 мянган төгрөгийн ухаалаг дэлгэц, Смарт старт ХХК-аас 17,160.0 мянган төгрөгийн компьютер тоног төхөөрөмж, Төгс нягт гурав аудит ХХК-тай Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулах гэрээ тус тус байгуулан ажилласан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтэс нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Энхзул гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дугаар сарын 23-ны өдрийн 20 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны батлагдсан төсөв 583,320.8 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 5,833.2 мянган төгрөг, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 65 хувиар буюу 3,791.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуульд хамаарах асуудал байхгүй бөгөөд тогтмол зардлыг 100 хувь зарцуулсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тайлант хугацаанд завсар үеийн аудит хийгдээгүй болно.

4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Батчимэг гүйцэтгэж аудитаар 40,127.8 мянган төгрөгийн 1 зөвлөмж, 4,425.3 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 539.9 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоосныг бүрэн биелүүлсэн талаар тус байгууллагаас 2024 оны 02 дугаар сарын 29-ны өдрийн 37 дугаартай албан бичгээр ирүүлэн, FAS программд хэрэгжилтийг мэдээлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	4,425.3	1	4,425.3	100%
	1	0	1	0	100%
Төлбөрийн акт	1	539.9	1	539.9	100%

Зөвлөмж	1	40,127.8	1	40,127.8	100%
Нийт дүн	4	45,093.0	4	45,093.0	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал Байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 14,100.0 мянган төгрөгийн 2 алдаа¹ илрэв. Үүнд:

1. Байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст тайлант онд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш 14,100.0 мянган төгрөгийн 1 гүйлгээг дутуу мэдээлсэн байна.
2. Мөнгөн гүйлгээний тайлангийн нэмэлт санхүүжилтийн данс зөрүүтэй байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст тайлант онд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш 14,100.0 мянган төгрөгийн 1 гүйлгээг дутуу мэдээлсэн байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Дээрх алдаа, зөрчлийг завсрын аудитаар залруулав.

Аудитаар илрүүлсэн нийт алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

-----oOo-----

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.